

Монголын бурхны шашны хүрээ хийдийн уламжлалт сургалтын тогтолцооны онцлог

О.Доржготов*

МУБИС, Дүрслэх урлаг технологийн сургууль, Дүрслэх урлагийн тэнхим

Хураангуй

Монгол оронд 1921 оны Ардын хувьсгалаас хойш л боловсролын цогц тогтолцоо бий болон хөгжиж эхэлсэн бөгөөд түүнээс өмнөх түүхэнд боловсролын тогтолцоо гэж огт байгаагүй, харанхуй бүдүүлэг нийгэм байсан гэсэн “түгээмэл ойлголт” өнөөгийн нийгэмд тогтсон байдаг. Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь чухам дээрх асуудалд хариулт өгөхөд чиглэсэн.

Үүний тулд Монголын бурхны шашны хүрээ хийдийн уламжлалт сургалтын тогтолцооны онцлогт судалгаа хийж, холбогдох ном, судалгааны эх сурвалжууд, Монголын дацан, сургуулиудын шашны гүн ухаан, анагаах ухаан, урлахуйн ухаан, зурхайн сургалтын талаар харьцуулан судлахад дээрх “түгээмэл ойлголт” эрс няцаагдаж байна.

Учир нь ХХ эхэн үед Монголд бурхны шашны сүм хийдэд тулгуурласан өргөн цар хүрээтэй, боловсролын цогц тогтолцоо бий болсон бөгөөд түүнд суралцагсдын тоо 100.000 хол давсан байжээ. Монгол оронд бий болсон энэхүү боловсролын тогтолцооны түвшин нь бурхны шашинт улсууд болох Энэтхэг, Түвдийн зиндаанд хүрч, дээрх улсуудын хамт “Номт гурван улс” хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн бөгөөд Монголчуудын оюун ухаан, боловсролын түүхэн дэх нэгэн том амжилт болжээ.

Түлхүүр үг

Шарын шашин, Дацан, Гавжийн дамжаа, Шүтээн урлал, Дээж өргөх, Оточ маарамба

Удиртгал

Монгол оронд 1921 оны Ардын хувьсгалаас хойш л боловсролын цогц тогтолцоо бий болон хөгжиж эхэлсэн бөгөөд түүнээс өмнөх түүхэнд боловсролын тогтолцоо гэж огт байгаагүй, харанхуй бүдүүлэг нийгэм байсан гэсэн түгээмэл ойлголт өнөөгийн нийгэмд тогтсон байдаг. Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь чухам дээрх асуудалд хариулт өгөхөд чиглэсэн болно. Үнэндээ тийм байсан эсэх нь эргэлзээтэй агаад түүхэн баримт, эх сурвалжууд үүнд өөр хариулт өгөх бөгөөд ХХ зууны эхэн үе хүртэл Монголд шарын шашны сүм хийдийн дацан, сургууль зонхилж иржээ. Гол төлөв угсаа гаралтай ноёд, язгууртны хүүхдүүд л гэрийн сургууль хамрагдаж байсан нь нийт хүн амын өчүүхэн бага хувийг эзэлж байв.

Миний бие Монголын бурхны шашны хүрээ хийдийн уламжлалт сургалтын тогтолцооны онцлогт судалгаа хийж, холбогдох ном, судалгааны эх сурвалжууд, Монгол, Түвдийн дацан, сургуулиудын шашны гүн ухаан, анагаах ухаан, урлахуйн ухаан, зурхайн сургалтын талаар харьцуулан судалсны эцэст энэхүү судалгааны ажлыг эмхэтгэлээ.

Судалгааны хэсэг

XV зууны үест Буддын шашны нэгэн

гол урсгал болох Богд Зонховын үндэслэсэн “Гэлүгва” ёсны буюу Шарын шашин Түвд оронд хүчтэй байр суурийг эзэлж, улмаар XVI зуунаас эхлэн Монгол оронд түгэн дэлгэрчээ. Цахарт төвлөрч асан Монголын их хаан Түмэн засагт анх 1576 онд Түвдээс Гармапа ёсны шашинг залсан бол түүний араас Түмэдийн Алтан хан 1577 онд Түвдээс шарын шашинг залжээ. Тэдний дараагаар Халхын Абатай сайн хан шарын шашинг Халхад залж, улмаар 1586 онд Эрдэнэзуу хийдийн суурийг тавьсан байдаг. Тэр цагаас хойш Монгол орон даяар 350 гаруй жилийн туршид шарын шашин улам хөгжиж, “1937 оны байдлаар нийтдээ 750 гаруй хүрээ, хийдэд 4000 шахам сүм, дуган, дацан байгуулагдаж, тэдгээрт 100 мянга хол давсан эрчүүд шавилан сууцгааж” (Очир, Энхтүвшин, 2003, х.211) байжээ. Ийнхүү шавилан суралцагсдын тоо хурдан өссөн нь харц ард, хамжлага хүний хүүхэд гэлтгүй нийгмийн шаталбараар дэвжин дээшлэх бололцоог хүрээ хийд олгодог байсантай холбоотой. Нөгөөтэйгүүр лам болох нь алба, гувчуур, татвараас хөнгөлөгдөх боломж байсан нь ч ихэд нөлөөлжээ. Иймийн учир хэт олон ламтай болох нь эргээд нийгмийн хөгжилд маш их хортой гэдгийг ойлгосон зарим “ноёд язгууртнууд эсрэг арга хэмжээг нэлээд авсан байдаг. Тухайлбал, “Халхын Тогтох ван лам нарыг шалгалт шүүлэгт оруулах замаар тоог цөөлөх

* ✉ dorjgotov@msue.edu.mn

хязгаарлах гэж оролдож байжээ...” (Батбаяр, 2006, х.210).

Хүрээ хийд, сүм дуган ийнхүү асар олноор баригдах болсноор тэнд шашны гүн ухаан, сургаал номлох эрдэм, чадалтай багш нар болон “сүм дуганы дотоод заслыг чимэглэж тохижуулах олон тооны зурмал болон цутгамал бурхдын хөрөг дүр, ном судрын зураг чимэглэл сэлтийг хийх чадвартай уран бүтээлчид, урлаачид эрхгүй шаардагдаж эхэлжээ” (Майдар, 1988, х.27).

Монголын сүм хийдүүдийн үндсэн захиргаа, бүтэц зохион байгуулалтын хувьд 1723 онд Манжийн хаанаас тусгай тамга олгож Богд Жавзандамба хутагтын захиргаанд байгуулсан “Их шавийн яам” нь шашны бүхий л хэргийг эрхлэх гол байгууллага байжээ. Энэхүү яамыг Эрдэнэшанзудба нар ээлжлэн удирдаж байсан бөгөөд үүнээс улбаалж Эрдэнэ Шанзудбын яам ч хэмээгддэг байв. Тус яам нь бүтцийн хувьд “аймгийн чуулганд эрхтэй бөгөөд Их хүрээний 30-н аймаг (Аймаг - сүм хийдийн засаг, захиргааны байгууллага О.Д), 10-н их дацан (“Дацан - Шашны ёсны лам хуврагийн сургуулилах орон сүм”(Цэвэл, 1966, х.193) Баруун хүрээ, Амарбаясгалант, Дамбадаржаалин, Эрдэнэзуу зэрэг томоохон хүрээ хийдийг харьяалан захирдаг” (Батсайхан, 2012, х.142) байжээ. Мөн Их шавийн яам нь өөртөө хүрээ хийдийн газрын эдийн засаг, санхүү, аж ахуйг хариуцсан сан болох “Жас” хэмээх байгууллагуудыг харьяалдаг байв. Учир нь хүрээ хийдэд хамаарагдах хөрөнгө, мал хуй нь тухайн үеийн Монголын нийгмийн баялгийн ихээхэн хувийг эзэлж байв. Тодруулбал 1873 оны байдлаар “нийт хүрээ хийдэд хамаарагдах өрх, аж ахуйтны тоо нь 9 916, хүн ам 83 983, нийт мал сүрэг нь хагас саяд хүрч” (Батбаяр, 2006, х.203) байв.

Хүснэгт 1

Дацан сургуулиудад бэлтгэгдэж байсан үндсэн 4-н чиглэл, мэргэжлийн сургалтын тогтолцооны бүтэц

№	Сургалтын үндсэн чиглэл	Нарийвчилсан мэргэжлийн төрөл	Харьяалагдах Дацан	Хугацаа	Шалгалт
1.	Буддын шашны гүн ухаан	Шашны гүн ухаантан Домч Гавж Аграмба	Жүдийн дацан Цанидын дацан Чойрын дацан Дашчоймпил дацан Гунгаачойлин дацан Идгаачойлин дацан Бадма-Ёго дацан	16-25 жил	Жил бүрийн хаврын адаг сард “Их шүүлэг” авч анги дэвшдэг байв. “10 орчим жил суралцаад “Домын дамжаа” барих эрхтэй болно. Түүний дараа 10-15 суралцсаны эцэст ном хаялцаж буюу тасга авснаар “Гавжийн дамжаа” барьж төгсөнө. “Гавжийн дамжаа” барьсан лам нар цаашлаад Жүдийн дацанд 4-5 жил суралцаад “Аграмбын дамжааг” барьж Мяндаг хүртдэг байжээ.” (Дамдинсүрэн, 1995, х.24)
2.	Анагаах ухаан	Оточ Маарамба Эм залаач Бариач	Мамба дацан	10-16 жил	Мамба дацанд суралцагч нь 10-16 жил суралцаад “Маарамбын дамжаа” барих эрхтэй болно.
3.	Байгалийн ухаан	Зурхайч	Зурхайн дацан	10-16 жил	

Нэг ёсондоо энэхүү яам нь Халхын 4-н аймагтай эн зэрэгцэхүйц эрх мэдэлтэй, олон хүн ам, мал сүргийг өөртөө агуулдаг байжээ. Харин Халхын тамгатай хутагтууд, хошуудын жижиг хүрээ хийдүүд нь Их шавийн яаманд захирагддаггүй байв.

Тухайн цагт Монгол орны шашин мөргөлийн гол төв болж байсан Их хүрээний 30 аймагт халхын бүх хошуудаас номын дуу сонсож, шавилан суухаар хүүхдүүд (эрэгтэй хүүхдүүд ихэвчлэн 10 гаруй наснаасаа хийдэд шавилан суудаг байв. О.Д) ирэх бөгөөд тэднийг хүрээний 10 их дацанд хуваарилан суралцуулдаг байв. Удирдлагын хувьд “Их хүрээний нийт лам нарыг Хамба Номун хан тэргүүлж, дэд хамба, цорж, гачин лам удаалах бол Буддын гүн ухааны 3-н гол сургууль болох Дашчоймпил, Идгаачойлин, Гунгаачойлин дацангуудыг шунлайв (захиралтай тэнцэхүйц албан тушаалийн Түвд нэршил О.Д) тэргүүлж, гэгсгүй умзад нар удаална. Харин Жүд, Зурхай, Мамба, Бадма-ёго, Майдар зэрэг бусад дацанг ловон, гэгсгүй лам нар удирддаг” (Цэдэндамба, 2003, х.76) байжээ.

Хүрээ хийдийн дацан “сургуульд гол төлөв бурхны сургаал, байгалийн ухаан, анагаах ухаан, урлахуйн ухаан гэсэн үндсэн 4-н төрлийн хичээлүүдийг заадаг байв.”(Батсайхан, 2012, х.154) Томоохон хийдүүд нь дэргэдээ оточ, маарамба бэлддэг Мамба дацан, зурхайч бэлддэг Зурхайн дацан, бурхан зураг, цутгуур дарх, сийлбэр, зээгт наамал, торгон зураг, цамын баг, өмсгөл, хувцас урлах зэрэг шүтээн урлалын төрлүүдийг бэлддэг урчуудыг багаас нь сонгож авьяас чадварыг сорьж, нээн хөгжүүлдэг урлахуйн сургууль дацантай байв. Тухайлбал Өргөөн сургууль, Эрдэнэзуу төвтэй сургууль зэргийг дурдаж болно.

4.	Урлахуйн ухаан	Бурхач - Шүтээн зураг Лавчин - Уран баримал, дархан, цуггуур Савын бичээч – Түвд үсгийн уран бичлэг Ном судрын зураг чимэглэл Бар сийлбэрч -Хэвлэлийн бар Ланз соёмбо бичээч - Уран бичлэг /Соёмбо, ланз үсгийн бичээч/ Торгон зураг – Зээгт наамал	Зүүн хүрээ, Гандантэгчилэн, Эрдэнэзуу, Амарбаясгалант зэрэг томоохон хүрээ хийдүүдэд суралцана.	16-25 жил	Жил бүрийн хаврын адаг сард “Их шүүлэг” авч анги дэвшдэг байв. 10 орчим жил суралцаад “Домын дамжаа” барих эрхтэй болно. Түүний дараа 10-15 суралцсаны эцэст бүтээлээр “Дээж өргөж” багш нартай хүлээн зөвшөөрөгдсөнөөр “Авшиг” хүртэж, бие даан бүтээл хийх эрхтэй болно.
----	----------------	---	---	-----------	--

Дээрх 4-н үндсэн чиглэл, мэргэжлийн сургуулийг нарийвчлан авч үзэхэд:

1. Буддын шашны гүн ухаан

Шинжлэх ухаан нь хүмүүсийн мэдлэг дээр суурилж, байгаль эд юмсын объектив талыг нь судлан нууцыг нь ойлгуулдаг. Харин шашин бол оюун санаа, төсөөлөл дээр суурилан хоосныг судалдаг төдийгүй гүн ухаан, боловсрол, соёл, урлаг, хүмүүжил юм. Ихэнх шашин олон жилийн түүх намтартай, өөрийн гэсэн үзэл санаатай, ёс журамтай учир хүмүүст бага наснаас нь сууж хүмүүжүүлж, ёс суртахууныг нь бий болгож, болох болохгүйн заагийг тогтоож өгдөг. Монгол нутагт Шарын шашин нэвтэрч эхэлснээр бөөгийн бүдүүлэг ёс, зан үйлийг халж, Энэтхэг, Төвөдийн соёлын ололтой талууд нэвтрэх бололцоотой болжээ. “Буддизм орж ирснээртэр үеийн Монголын нийгэмд том дэвшил болсныг үгүйсгэх аргагүй юм...” (Батбаяр, 2006, х.164). Бурханы шашны гүн ухааны сургалт гэдэг нь маш нүсэр, олон жил судлах зүйл болдог. Тухайлбал, христосын шашны судалгаа “Библи” дээр, исламын шашин судлал “Коран” судар дээр төвлөрдөг бол Буддын шашин судлах гол эх сурвалж гэхэд бурхан багшийн амьд ахуйдаа бүтээсэн 100 орчим судрууд, тэдгээрийн тайлбарууд болох Данжуурын 200 гаруй боть судар дээр тулгуурладаг. Иймд буддын гүн ухааны дацан, сургуулиудын хамгийн богино хөтөлбөр нь 16 жил бөгөөд 25 жил хүртэл судалж байж, 2500 жилийн түүхтэй буддын гүн ухааны талаар цогц мэдлэгтэй болох боломжтой юм.

Тухайн цагийн томоохон хүрээ, хийдүүдийн Жүдийн дацан, Цанидын дацан, Чойрын дацан, Гандантэгчилэн хийдийн Дашчоймпил дацан, Гунгаачойлин дацан, Идгаачойлин зэрэг дацангууд бурхны шашны гүн ухааны сургалт, судалгааг ул суурьтай явуулж ирсэн бөгөөд шавь хүүхдүүдийг 10 орчим наснаас эхлэн сургадаг байжээ. Улмаар жил бүрийн хаврын адаг сард “Их

шүүлэг” авч анги дэвшдэг байв. 10 орчим жил суралцаад “Домын дамжаа” барих эрхтэй болно. Түүний дараа ахин 10-15 суралцсаны эцэст ном хаялцаж буюу тасга авснаар “Гавжийн дамжаа” барьж төгсөнө. “Гавжийн дамжаа” барьсан лам нар цаашлаад Жүдийн дацанд 4-5 жил суралцаад “Аграмбын дамжааг” барьж Мяндаг хүртэх боломжтой байжээ. Энэ нь өнөөгийн ойлголтоор бол докторын зэрэг хамгаалсантай дүйх бөгөөд сүүлийн үед Харвард, Стэнфорд зэрэг дэлхийн шилдэг их сургуулиуд Бурханы шашин судлалын тэнхим, төвтэй болон судалгаа, шинжилгээ хийж буй нь Буддын гүн ухаан хүмүүсийн амьдралд эергээр нөлөөлж, зөв амьдрах хандлагыг бий болгодогтой холбоотой юм.

Монголын хүрээ хийдийн бурхны шашны голлох игчаа (*Игчаа - онолын гол сурах бичиг, сургалтын материал О.Д*) дээр дурдсан Бурхан багшийн 100 боть судар, тэдгээрийн тайлбар толиуд болох Данжуур, Ганжуур, Шарын шашныг үндэслэгч Богд Зонховын “Бодь мөрийн зэрэг” шастир, Энэтхэгийн гүн ухаантан Дарма Кирдийн «Нам дэл заваа» зэрэг судар, ном зохиолууд бөгөөд эдгээрийг баримтлан сургалт, судалгаагаа явуулж иржээ.

Түвдийн шашны гүн ухааны үндсэн 3-н их сургууль болох Сэра, Гандан, Барайван дацангуудын гол номлолууд болох гүн ухаантан, судлаач Сэржавзанбын бичсэн «Сэрийн игчаа», гүн ухаантан, их сэтгэгч Банчинсономдагвын гаргасан «Банчин игчаа», Гүнчинжамьяншадавын гаргасан «Гүнчин игчаа» гэсэн 3-н гол игчааг үндэслэн Гандантэгчилэн хийдэд шашны энэ 3-н их сургууль байгуулагдсан байдаг. Тэдний хамгийн ууган дацан нь 1736 онд байгуулагдсан “Дашчоймпил” дацан бөгөөд Түвдийн Гүнчин игчаагаар сургалтаа явуулж байжээ. Дараагаар нь IV Богд Жавзандамбын үед Банчин игчааг барьсан “Тунгаачойлин” дацан, VIII Богд Жавзандамбын хутагтын үед Сэра игчаагаар хичээлээ явуулдаг

“Идгаачойзэнлин” дацанг 1912 онд тус тус байгуулжээ. Дээрх 3-н дацан бол тухайн үедээ бурхны шашны гүн ухаан, номлолыг судлах гол сургуулиуд болж байсан бөгөөд XX зууны эхэн үед хөгжлийнхөө оргилд хүрч, жил бүр дор хаяж 50-60 орчим хувраг “Гавжийн дамжаа” барьдаг байжээ.

2. Анагаах ухаан - Мамба дацан

Монгол оронд бурхны шашин дэлгэрснээс хойш томоохон хүрээ хийдүүд дэргэдээ Мамба дацан буюу эмчийн дацанг байгуулж, оточ маарамбуудыг сурган бэлтгэж эхэлжээ. Учир нь ард олныг эрүүлжин анагаах салбар ч аанай л хүрээ хийдийн маарамбын газарт оногдож байв. Оточ нар судас барьж, өвчнийг оношлох, эм тан залж илааршуулах зэргээр олонд үйлчилдэг байв. Тэр цагийн уламжлалт анагаах ухааны сургууль, дацанд Түвд, Энэтхэгийн орчуулгын зохиолууд голлох игчаа, сурах бичгийн үүргүүдийг гүйцэтгэж эхэлжээ. Тухайлбал: Монголын алдартай эрдэмтэд, оточ нарын хамтран орчуулсан “Данжуур”-ын 108 ботийн судрын тайлбарын 206-210 дугаарын анагаах ухааны салбарын ботиуд, оточ эмч бэлтгэх сургуулийн үндсэн сурах бичиг болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Хатгах төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр” зэргийг дурдаж болно.

Аажимдаа Монгол маарамба, оточ нар өөрсдөө бичсэн “Рашааны дусал”, “Увдисын далай”, “Хиргүй болор эрхийн номлосон эмийн ургамал”, “Товчхон төдий хураасан чулуун эмийн тухай тэмдэглэл” зэрэг олон арван сурах бичгүүдийг сургалтад ашиглах болжээ. Монголд XVII зууны сүүлчээр Ламын гэгээний хүрээ дээр хамгийн анхны Мамба дацан байгуулагдсан бол дараагаар нь “Их хүрээнд “Соригшампанлин” Мамба дацан, Заяын хүрээ, Тариатын хүрээ, Ханд вангийн хүрээ зэрэгт тус тус нээгдсэн” (Батсайхан, 2012, х.228) нь тухайн цагийн нийгмийн хэрэгцээ шаардлагаар байгуулагдаж байв. Мамба дацанд хүүхдүүдийг бага наснаас нь эхлэн шавилан суулгаж, анагаах ухааны холбогдолтой уншлага номуудыг цээжлүүлж, улмаар анагаах ухааны сурах бичгүүдийг судлуулдаг байв. Үүний хойно хануур төөнүүр, зүү, судас барих, эм тан найруулах зэрэг практик хичээлүүд дээр мэргэшүүлэхээс гадна 2000 гаруй төрлийн эмийн түүхий эд болох ургамал, эрдэс чулуу, төмөрлөг, амьтны гаралтай зүйлсийг танин мэдүүлдэг болгодог байв. Дээр дурдсанчлан “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн дагуу Язгуур, Номлол, Увдис, Хойдын гэсэн үндсэн 4-н зиндаанд дэвшин нийтдээ 10-16 жил суралцсаны эцэст “Маарамбын дамжаа” барих

эрхтэй болдог байжээ.

Монгол оточ маарамбын эмчлэхүйн арга ухаан тухайн цагийн өрнө дорнын анагаах ухааны түвшингээс хол зөрүүгүй, эн зэрэгцэн хөгжиж, зарим талаараа ололт амжилттай гаргаж байсныг судлаачид тэмдэглэн үлдээсэн байдаг. Тухайлбал, “онол, практикт өмнө байгаагүй шинэчлэлийг хийсэн эмчилгээний арга, засал, шинэ эм олныг нэвтрүүлж байжээ.” (Чулуун, 2014, х.207) Мөн дорнын анагаах ухааны түүхэнд судалгаа шинжилгээний өндөр ач холбогдолтой олон арван судалгааны зохиол, ном судар бичиж үлдээсэн нь өнөөг хүрчээ.

3. Байгалийн ухаан - Зурхайн дацан

Монголын ард түмэн нэн эртнээс нүүдлийн мал аж ахуйг эрхлэх явцдаа од мичдийн хөдөлгөөн хүний амьдралд хэрхэн нөлөөлж буйг судлан ном сударт тусган өөрсдийн амьдрал ахуйд ашиглан хэрэглэж иржээ. Олон жилийн ажиглалтын дүнд элдэв эрхсийн тохиол, нар, сарны явдал нь байгаль цаг уурт тодорхой нөлөө үзүүлдгийг олж мэдэн нар, сар, мичдийн тооллыг хэрэглэдэг байв. Зурхайн ухааны эртний судрууд “Энэтхэг, Төвөдөөр дамжин Монголд орж ирэхдээ тухайн бүс нутгийн онцлог, хүн ардын зан заншил, уламжлалтай уялдан өөрийн гэсэн онцлогтойгоор хөгжжээ.” (Мөнх-Очир, 2012, х.4) Бурхан Будда өөрөө туурвисан гэх “Калачакра тантра раджа” судар нь одон орон зурхайн ухаан хамгийн эртний туурвилын хувьд Энэтхэг, Түвд, Монголын зурхайн ухааны голлох эх сурвалж болж байв. Түвдийн одон зурхайн анхны дорвитой бүтээл туурвисан хүн бол Гармаваа Ранжүндорж бөгөөд 1318 онд “Бүхнийг хураасан зурхай” гэдэг алдартай бүтээлээ туурвисан байна. Мөн Цүрпүваа Жамьяандондов-одсэр, Пүгваа Лхүндэвжамц нарын зурхайч эрдэмтэд Түвдэд “Цүр”, “Пүг” хэмээх зурхайн анхны хоёр сургууль байгуулсан байдаг. Пүг зурхайн ёсны дараагийн гол төлөөлөгч нь Дэсрид Санжаажамцын 1687 онд зохиосон “Зурхайн гол цагаан биндэрьяа” хэмээх зохиолдоо Төвөдийн газрын хуваарьт гараг, эрхсийн хөдөлгөөнийг тооцоолон бодох арга, цаглавар зохиох аргачлалыг голлон дурдсан байдаг.

Монголд Бурханы шашин дэлгэрэхийн зэрэгцээ “томоохон хүрээ, хийдүүдэд Дүйнхор, Зурхай дацан, сургуулиуд байгуулагдах болов. Тухайлбал: Их хүрээнд 1789 онд “Цагаан биндэрьяа” зурхайг дагасан Зурхай дацан, Дэчингалавын сүмд 1806 онд “Цагийн Хүрдэний Язгуур үндэс” зурхайг дагасан Дүйнхор дацан байгуулагдав.” (Тэрбиш, 2003, х.12) Суралцагч шавь хүүхдүүд 10 орчим наснаас дээрх дацан,

сургуулиудад элсэн орж, байгалийн ухаан, газар зүй, одон орон, цаг уур, зурхайн хичээлүүдийг судалдаг байжээ. Шавь нар жил бүрийн хаврын адаг сард “Их шүүлэг” өгч анги дэвшдэг байв. Тэгээд 10 жил суралцаад “Домын дамжаа” барих эрхтэй болно. Түүний дараа аанай л 10-15 жил суралцсаны эцэст “Гавжийн дамжаа” барьж зурхайч болдог байв. Дацангууд одон орон, зурхайн ухааныг заан, түүгээр мэргэжсэн олон эрдэмтэн лам нарыг төрүүлэн улмаар Монгол даяарх бүхий л хүрээ хийдүүд дэргэдээ зурхайн дацангуудыг буй болжээ.

Тухайн үед Зурхай, Дүйнхорын дацангуудын “Да зурхайч” хэмээх цолтой голлох эрдэмтэн, зурхайчид нь хамтран 12 жилээс Нэгэн жаран жил хамаарах цаг тооны бичгийг барлан хэвлүүлж, хошуу хүрээдийн Зурхай дацангийн зурхайч лам нарт тараадаг байжээ. Энэхүү цаг тооны бичиг нь Монголын нэрт эрдэмтэн Сүмбэ хамба Ишбалжирын 1747 онд бичсэн “Зурхайн гол төгс буянт шинэ зурхай эх, хөвгүүн судар”-д тулгуурласан байжээ. Энэхүү “Төгсбуянт” хэмээх зурхайн сударт Монгол орны өргөн уудам нутаг, газрын хуваарьт тохирсон гараг, эрхсийн хөдөлгөөн байршлыг хөөн олж, цаглавар зохиох аргыг нарийвчлан боловсруулсан байжээ. Тэрхүү шинэ зурхай нь гараг, эрхсийн хөдөлгөөнийг нэг секундийг 149209 хуваасантай тэнцэх их нарийвчлалаар боддог нь орчин үеийн шинжлэх ухааны аргаар бодсонтой дүйдэг байна. Монголчууд өнөөг хүртэл тэрхүү уламжлалт “Төгсбуянт” зурхайн ухааныг даган мөрдөж, он жил, сар улирал, өдөр судраа тогтож, амьдрал ахуйдаа ашиглаж иржээ.

4. Урлахуйн ухаан

XVII-XX зууны эхэн бурхан зураг, шүтээн урлалын бүтээх арга, ажиллагаа нь Монгол үндэстний өвөрмөц онцлогтой уялдаатай байж, үе улиран улам боловсрогдож, шашны нөлөөн доор хөгжиж ирсэн байдаг юм. Тухайн үеийн бурхач зураачид бага наснаасаа дацан хийдүүдэд шавилан сууцгааж, зураг зурах арга барилыг тусгай дэг, сургуулиар сурч, сонгодог уламжлалыг өвлөсөн уран бүтээлч нар болдог байв. Тухайлбал: Их хүрээний 30-н аймгаас гарын дүйтэй, авьяаслаг хүүхдүүдийг сонгон авч, бурхан зураач багш нарыг дагалдуулан суралцуулдаг журамтай байх ба доорх чиглэлүүдээр суралцана.

Үүнд: Бурхач - Шүтээн зураг
Лавчин - Уран баримал, дархан, цутгуур
Савын бичээч – Түвд үсгийн уран бичлэг
Ном судрын зураг чимэглэл
Бар сийлбэрч - Хэвлэлийн бар

Ланз соёмбо бичээч - Уран бичлэг /Соёмбо, ланз үсгийн бичээч/

Торгон зураг - Зээгт наамлын төрлүүдээр 10-15 жил орчим тухайн мэргэжлийнхээ багшийг даган суралцаж, дүрслэн бүтээх арга барилыг эзэмшин авсны хойно өөрсдийн бүтээлээр “Дээж өргөж” (Дамдинсүрэн, 1995, х.83) багш нартай хүлээн зөвшөөрөгдсөнөөр “Авшиг” хүртэж, бие даан бүтээл хийх эрхтэй болдог байжээ. Үүний дараа уран барилгач, зураач бурхач, лавчин барималч мэргэжлээр үргэлжлүүлэн суралцаж, сүм дуган барих, тиг гориг тавих, зураг зурах онолын ном судлах зэргээр 10 орчим жил суралцаж “Гавжийн дамжаа” барьдаг байсан нь онолын мэдлэг, өндөр ур чадварыг багтай суулгадаг байв.

Эртний Энэтхэг, Түвдээр дамжин Монголд оронд нэвтэрсэн 10-н эрдэм ухааны нэг болох “Со-ригва буюу урлахуй ухааны онолд бурхны лагшин дүр бүтээх арга, тигийг тодорхой зааж өгсөн байх агаад бурхдын дүрийг шашны домогт өгүүлснээр уран сайхны хэтрүүлэгтэй бүтээхийг зөвлөсөн” (Сарантуяа, 2009, х.144) байдаг. Энэ үзэл баримтлалын тууштай барьж байсан халхын Анхдугаар Богд Живзундамба хутагт Өндөр гэгээн Занабазар өөрийн гэсэн дэг, уран хийц бүхий уран баримлын бүтээлүүдийг урлаж эхэлсэн байдаг. Хожим нь түүний өөрийн болон дэг жаягаар нь шавь нарынх нь урласан бурхны шүтээний урлалуудыг бүхэлд нь Занабазарын сургуулийн бүтээл, хийц хэмээн нэршсэн байдаг.

Тухайн цагийн урлахуйн ухааны гол игчаа буюу сурах бичгүүдийн дотор Жадарын аймгийн дэд хамба Агваанхайдавын бичсэн “Утга төгөлдөр, уран үйлдэгч тэнгэрийн сайн зам” хэмээх судар урлан бүтээх гол гарын авлага болж байжээ. Мөн Агваанхайдавын бичсэн “Сүмбүм”-д бурхдын хөрөг дүрийг бүтээхдээ зураач хүн Төвд Энэтхэгийн эртний будда болон бусад бурхдын тиг хэмжээ зааврын дагуу зөв хийж, өөрийн ур чадварыг гаргаж урлахыг чандлан заасан байдаг. Түүнчлэн IV Богдын үед Их хүрээнд хэвлэгдсэн “Таван зуут” хэмээх бурхдын дүр бүтээх загваруудтай гарын авлага номыг Хүрээний сургууль төгсгөн шинээр “Дээж” бүтээлээ өргөж, жинхэлж буй лавчин, бурхач нарт Богд Живзундамба хутагтын өргөөнөөс олгодог байжээ. Үүн дээр Түвд хэлээр хэвлэгдэн гарсан “Турван зуут” гэдэг бурхны тэг, загварын номыг түлхүү хэрэглэж байжээ. Тухайн цагт дээрх гарын авлага, ном судруудыг бурхач зураач, лавчин барималч нар бурхны тиг дүр бүтээхдээ ашиглаж иржээ.

Хэдийгээр тогтсон онол, загвартай боловч

шүтээн зураг нь Монгол оронд хөгжихдөө нүүдэлчин ард түмний амьдралын хэв маяг, зан заншил, уламжлалт урлаг соёлтой сүлэлдсэн байдаг. Тухайлбал, бурхдын шүтээн зураг болон цутгуур баримал нь сүм хийдэд зориулсан томоохон хэмжээтэй байхаас эхлүүлээд айл гэрт зориулсан тээвэрлэхэд тохиромжтой эмхэлж хуйлдаг, хувь хүн биедээ авч явахаар жижиг хэмжээтэй хүртэл байдаг байв. Эндээс үзэхэд тухайн цаг үед хүрээ хийдэд л шавилан сууж байж гэмээнэ бүтээл туурвил хийх ур чадвартай, эрхтэй болох агаад сүм хийдийн газарт л зургийн хэрэглэл болох бийр янтай, шороон будаг, пайтуу, цавуу, тэлүүр рам, цардмал давуугаа боловсруулах гээд бүхий л технологи тэнд байдаг байжээ.

Цам дэглэлт

Түүнчлэн дацан, сургуулийн хэмжээнд биш ч гэлээ өөрийн тогтсон арга, хэлбэрээр бэлтгэл, сургалт явуулж байж зохион байгуулдаг Цам, Майдар эргэх зэрэг шашны арга хэмжээнүүд байв. “Цам бол алив зовлон зүдгүүр, муу бүхний үндсийг таслан амарлиулах зорилготой шашны уламжлалт зан үйл, нууц тарнийн дияаны бясалгал, бөгөөд нөгөө талаасаа соёл урлагийн нандин өв” (Батсайхан, 2012, х.234) юм. Их хүрээний Зүүн хүрээ, Эрдэнэзуу, Манзушир, Амарбаясгалант зэрэг цам гаргадаг томоохон хүрээ хийдүүдэд жил бүрийн хаврын эхэн сараас эхлэн зуны адаг сарын эхэн хүртэл мяндаг тушаалтай багш ламын удирдлага дор цамын бүжгийн “Цэсэм” дэглэлтийн бэлтгэл хийдэг байв. Мөн цамын хөгжмийн зэмсгүүд болох гандан, цан, бишгүүр, бүрээчдийн бэлтгэл давхар явагддаг байжээ. Зөвхөн “Их хүрээний Жажор цамд гэхэд 108 дүр байдаг бөгөөд үүнд дор хаяж 70 гаруй цамчин дэглэж тоглодог” (Дамдинсүрэн, 1995, х.17) байв. Цамд тоглогдох гол хөгжмийн зэмсгүүд бол гандан, цан, хэнгэрэг, бишгүүр, бүрээ бөгөөд тэдгээрийг тоглогчид нь цамын чуулга бүжгийн хөгжмийн ая данг тааруулж тоглодог байв.

Эрлэг номун хаан - Дамдинчойжоо, Улаан сахиус - Жамсран зэрэг зарим цамын гол дүрийн өмсгөл, хувцас, зүүсгэл, баг сэлтийг иж бүрнээр өмсөөд цамын харайхад тухайн цамчингаас асар их гэсвэр тэвчээр, ур чадвар, чадал тэнхээ шаарддаг учраас ихээхэн цаг хугацаа зарцуулж бэлтгэл сургуулилалт хийх хэрэгтэй болдог байв. Учир нь цамын эдгээр дүрийн баг, өмсгөлийн иж бүрдэл ойролцоогоор 30-70 гаруй кг хүртэл жинтэй байжээ. Мөн их хүрээнд жил бүрийн зуны адаг сарын шинийн 4-нд болдог “Чогор” хэмээх цам тахилгын үеэр Богдын шар ордны өмнө тусгайлан босгосон модон тэлүүрт (раманд) тэлж өлгөдөг

Очирдарь тэргүүтэй гурван том бурхдын хөрөг дүрүүдийг Гандан хийдээс харахад танигддаг байжээ. Түүнчлэн Цам, Майдар эргэх зэрэг томоохон шашны баяр ёслол нь тархай бутархай нүүдэлчин ард олны хувьд мэдээллээ солилцох гол газар болох бөгөөд хол ойрын бүхий л хүмүүс нэг дор цуглаж, сонин сайхан яриа хөөрөө дэлгэж, худалдаа арилжаа хийдэг байжээ.

Хүрээ хийдийн дацан, сургуулиудад бэлтгэгдэж байсан үндсэн 4-н чиглэл, мэргэжлийн сургалтын талаар товчхон дурдахад ийн бөгөөд 1970 онд Гандантэгчилэн хийдийн дэргэд байгуулагдсан Монголын Бурханы Шашны Их Сургууль нь дээрх үндсэн уламжлалт чиглэлүүд болох шашны гүн ухаан, уламжлалт эм, зурхай, урлахуйн салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүгнэлт

XX зууны эх хүртэл Монгол оронд буддын шашны гол урсгалын нэг шарын шашин хүчтэй хөгжсөн бөгөөд түүнийг дагаад 1586-1930 оны хооронд орон даяар байгуулагдсан том жижиг 1.000 гаруй хүрээ хийд нь бага, дунд, дээд түвшний сургалтыг шашны гүн ухаан, байгалийн ухаан, анагаах ухаан, урлахуйн ухаан гэсэн үндсэн төрлүүдээр явуулж иржээ. Орон нутгийн чанартай хошууны жижиг хийд, дуган нь бага, дунд түвшний сургалтыг, Их хүрээ, аймгийн хэмжээний томоохон хүрээ, хийд нь дээд түвшний сургалтыг илүү удаан хугацаанд хөтлөн явуулдаг байжээ. Тухайлбал 1736 онд байгуулагдсан Дашчоймпилын дацан бол Монгол оронд хамгийн өргөн цар хүрээтэй сургалт, судалгаа явуулдаг анхны “институт” байжээ.

Мөн Буддын шашин судлал өрнөдөд 100 гаруй жилийн түүхтэй бөгөөд сүүлийн үед дэлхийн томоохон их сургуулиуд дэргэдээ Бурханы шашин судлалын тэнхимтэй болж, эрдэмтэн, судлаачид нь өргөн хүрээтэй, гүн гүнзгий судалгаа, шинжилгээ хийж буй нь Буддын гүн ухаан, номлол сургаал нь хүмүүсийн амьдралд эерэг зөв амьдрах хандлагыг бий болгодогтой холбоотой гэж үзэж болно. Монгол оронд ч уламжлалаа даган бурхны шашныг зөв хандлагаар ойлгож танин мэдэх, судлах хэрэгцээ эрдэмтэн судлаачдад тулгарч байна.

Удиртгал хэсэгт дурдсанчлан Монгол оронд 1921 оны Ардын хувьсгалаас хойш л боловсролын цогц тогтолцоо бий болсон бөгөөд түүнээс өмнө боловсролын тогтолцоо гэж огт байгаагүй хэмээх түгээмэл ойлголт энэхүү судалгаагаар няцаагдаж байна. Учир нь XX эхэн үед Монголд

бурхны шашны сүм хийдэд тулгуурласан өргөн цар хүрээтэй, боловсролын цогц тогтолцоо бий болсон бөгөөд түүнд суралцагсдын тоо 100.000 хол давсан байжээ. Монгол оронд бий болсон энэхүү боловсролын тогтолцооны түвшин нь бурхны шашинт улсууд болох Энэтхэг, Түвдийн зиндаанд хүрч, дээрх улсуудын хамт “Номт гурван улс” хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн бөгөөд Монголчуудын оюун ухаан, боловсролын түүхэн дэх нэгэн том амжилт болжээ.

Ашигласан материал

Батбаяр, Б. (2006). Монголчууд: Нүүдэл суудал I дэвтэр. Улаанбаатар.
 Батсайхан, О. (2012). Монголчууд XX зууны эхэнд. Улаанбаатар.
 Дамдинсүрэн, Д. (1995). Их хүрээний нэрт урчууд. Улаанбаатар.

Майдар, Б. (1988). Монголын зураасан зураг. Москва.

Мөнх-Очир, Д. (2012). Монголын одон орон, зурхай судлалын түүх. Улаанбаатар.

Очир, А., Энхтүвшин, Б. (2003). Монгол улсын түүх. Боть IV. Улаанбаатар.

Сарантуяа, У. (2009). Урлахуй, шүтэхүй, гэгээрэхүй. Нүүдэлчдийн өв судлал. Улаанбаатар.

Ринчен, Б. (1957). Монгольская национальная живопись. Искусство №10. Москва.

Тэрбиш, Л. (2003). Монгол зурхайн ухаан. Улаанбаатар.

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.

Цэдэндамба, С. (2003). Монгол улс дахь шашны нөхцөл байдал. Улаанбаатар.

<http://budda.mn>

<http://niitlech.mn>

<http://www.mongoliantemples.org/index.php/mn/>

Characteristic of Mongolian educational system based on the Buddhist temples

O.Dorjgotov

*Mongolian National University of Education
 School of Fine Art and Technology, Department of Fine Art*

Abstract

In modern Mongolian society, there has been an absolutely wrong understanding of “common sense”. Before the People’s Revolution in 1921, Mongolia was an uneducated barbaric nation because it didn’t have any kinds of its own educational system and after the People’s Revolution, it had created a comprehensive educational system. The main target of this research is to clarify and to find an answer for this issue.

But, this “common sense” is easily dismissed after studying and comparing Buddhist philosophy, Buddhist traditional medicine, fine art and astrology classes of Buddhist temples and monasteries in Mongolia and other related books, research materials about on the traditional educational system of the Buddhist temples and monasteries of Mongolia.

In conclusion, Mongolia had its own educational system based on the Buddhist temples and monasteries at the beginning of the 20th century and over 100.000 monks studied at those schools. Furthermore, its level was reached to the same high level of other Buddhist schools in two other Buddhist countries - India and Tibet, and including these countries it was called “The Great three nations of Buddhist Studies” and it became one of the greatest historical achievements of Mongolian history of education and intelligence.

Keyword

Gelugpa, Datsan /Monastery/, Course of Gavja, Thangka painting, Deej urguh /To take an exam/, Otoch Maaramba /Medicine in Buddhism/